

ТӨВ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272262., Факс: 702721922020.05.05 № 07/354
танай _____-ны № _____-тТендерийн тодруулга хүргүүлэх
тухай

Орон нутгийн өмчийн газраас зарлагдсан ТӨАОНӨГ/202004091 тоот дугаар бүхий аймгийн нийтийн номын сангийн их засварын тендерт оролцогч “Баян орхон дэлгэрэх” ХХК-аас 2020.04.30-ны өдөр тодруулга авахаар албан хүсэлт ирүүлсэнийг манайд уламжилсан. Албан хүсэлтээр ирүүлсэн 3 заалт бүхий хүсэлтийн дагуу дараах тодруулгыг хүргүүлж байна. Үүнд:

1. Барилгын ажлын зураг болон интьерьерийн 3D зургийн зөрүүг нийтийн номын сангийн барилгын их засварын ажлын төсөвт тусгагдсан тул 3D зургийг баримтлан холбогдох норм дүрэм, стандартын дагуу тендерийн төсөвт тусгах.

2. Дээврийн парпедний гөлмөн төмөр, ус зайлуулах төмөр хоолойг аймгийн нийтийн номын сангийн барилгын их засварын зураг /Ажлын зураг/-ийн БА-11, БА-12 дугаар хуудсанд заасны дагуу тендерийн төсөвт тусгах.

3. Аймгийн нийтийн номын сангийн их засварын ажилд дотор тавилга, гадна талбайн тохижилтын ажлууд хасагдаж төлөвлөгдсөн тул тендерийн төсвөөс хасч тооцон ирүүлэхийг мэдэгдье.

Мөн аймгийн Засаг даргын 2019.12.12-ны А/629 дүгээр захирамжаар захиалагч байгууллагаар аймгийн Барилга захиалагч, орон сууц корпораци ОНӨҮГ-г томилсон тул тус байгууллагад хандах нь зүйтэй.

Хувийг: Барилга захиалагч, орон сууц корпорацид

ДАРГА

М.ОТГОНБАТ

